



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 04 сарын 12 өдөр

Дугаар А/60

Ховд

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Ховд аймгийн Чандмань сумын Спорт заалны барилгын засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Н.Эрдэнэцэцэг – Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн

Гишүүд: С.Мөнх-Очир -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн

Б.Батзол - Төрийн бус байгууллагын төлөөлөл

Г.Бямбадорж - Иргэний төлөөлөл

Нарийн бичгийн дарга:

Ж.Батлхагва -Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

2. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо / Н.Эрдэнэцэцэг /-нд үүрэг болгосугай.

3. Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга / Ж.Батлхагва /-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД